



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/368

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-гийн "г" заалт, Захиргааны ерөнхий хуулийн 40.2.3, 40.2.5, 94.1 заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 70.1 заалт, Төрийн аудитын тухай хуулийн 28.1 заалт, Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 заалт, 26 дугаар зүйлийн 26.1.1, 26.3 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар батлагдсан журмын 4.2.2, 4.3.3, 5.1 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г Сувд)-д үүрэг болгосугай.

2. Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг харъяа сум, байгууллагад хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга, төсвийн шууд захирагч, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагнал, өмч хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг орон нутгийн өмчид шилжүүлэн авах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Б.Болд)-д даалгасугай.

4. Харъяа байгууллагынхаа анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан баланс гаргалт, тооллого, тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг шалган зааварчлах, санхүүгийн ажилтнуудын ажлыг улирал бүр дүгнэх, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн холбогдох журнал, ерөнхий данс, тооллого, тооцооны материалтай тулган, шалгаж хүлээн авч, нэгтгэн, үнэлэлт дүгнэлт өгч, холбогдох удирдлагуудад мэдээлэхийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Мөнхтуяа), сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

5. Санхүүгийн ажилтнуудыг шагнаж, урамшуулах, үр дүнгийн урамшуулаг олгох, дээд шатны байгууллагын болон төрийн шагналд тодорхойлохдоо улирал хагас болон бүтэн жилийн ажлын үр дүнг харгалзан, харъяалах аймаг, сумын

төсвийн ерөнхий нягтлан бодогчийн саналыг үндэслэхийг төсөв захирагч нарт даалгасугай.

6. Орон нутгийн төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Сувд)-д үүрэг болгосугай.

7. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг сайжруулах, өмнө өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулах, эрсдлийн үнэлгээ хийж, эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулахыг Санхүүгийн хяналт, аудитын алба (В.Нэргүй)-д даалгасугай.

8. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон малжуулах төслийн өр төлбөрийг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авахыг сумын Засаг дарга нарт, хяналт тавьж, үр дүнг тооцохыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Г.Баттулга), Санхүүгийн хяналт, аудитын алба (В.Нэргүй) нарт даалгасугай.

9. 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар "Зөрчилгүй" дүгнэлт авсан сумын Засаг дарга нарт олгох урамшууллын хувь хэмжээг 1 дүгээр хавсралтаар, аймгийн төрийн сантай шууд харилцдаг байгууллагын төсөв захирагч, санхүүгийн ажилтнуудад олгох балансын үр дүнгийн урамшууллын хувь хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

10. Аудитын алдаа, зөрчлийн дүнг өмнөх оны дүнтэй харьцуулан холбогдох хууль журмын дагуу харъяа орон нутгийн төсөвт байгууллагын төсөв захирагч болон санхүүгийн ажилтнуудад батлагдсан цалингийн сандаа багтаан үр дүнгийн урамшуулал олгохыг сумын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

11. Боловсролын болон эрүүл мэндийн байгууллагын төсөв захирагч, санхүүгийн ажилтнуудад батлагдсан төсвийн хүрээнд балансын үр дүнгийн урамшуулал олгох саналыг Санхүү, төрийн сангийн хэлтэстэй зөвшилцөж хүргүүлэхийг Боловсрол, соёл урлагийн газар (Я.Дашзэвэг), Эрүүл мэндийн газар (Н.Үүрийнбаяр) нарт даалгасугай.

12. 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан Шинэ-Идэр сумын Засаг дарга Т.Гомбосүрэн, Цэцэрлэг сумын Засаг дарга Я.Цогт нарт сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай

13. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд "Зөрчилгүй" дүгнэлт авсан Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувд, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч Ц.Мөнхтуяа нарт батлагдсан төсөвтөө багтаан урамшуулал олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д зөвшөөрсүгэй.

14. Захирамжийг эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

ДАРГА

Л ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар
сарын 25-ны өдрийн А/368 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

№	Байгууллагын нэр	Урамшууллын хувь (сарын цалингаас тооцох)
1	Аймгийн ЗДТГ	100
2	Аймгийн ИТХ	60
3	БОАЖГазар	60
4	ОНӨГазар	100
5	СХААлба	60
6	ГХБХБГазар	100
7	ГБХЗХГазар	60

Аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар
сарын 25-ны өдрийн А/368 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

№	Сумын нэр	Нийт алдаа болон зөрчлийн дүн	Хувийн жин	Залруул агдаагүй алдаа	Урамшууллын хувь (сарын цалингаас тооцох)	Тайлбар
1	Цагаан-Уул	4.6	0.16		100.0	
2	Хатгал	5.8	0.20	2.4	90.0	
3	Рэнчинлхүмбэ	19.1	0.65		90.0	
4	Рашаант	19.9	0.67	0.9	60.0	Алдаа, зөрчлийн хэмжээ бага боловч өмнөх оноос өссөн
5	Тариалан	36.1	1.22		60.0	Алдаа, зөрчлийн хэмжээ бага боловч өмнөх оноос өссөн
6	Бүрэнтогтох	39.4	1.33		80.0	
7	Тосонцэнгэл	41.6	1.41		70.0	
8	Түнэл	41.9	1.42		70.0	
9	Баянзүрх	54.1	1.83	0.3	60.0	
10	Их-Уул	60.7	2.05		50.0	алдааны хэмжээ өмнөх оноос өссөн
11	Төмөрбулаг	65.4	2.21		50.0	алдааны хэмжээ өмнөх оноос өссөн
12	Эрдэнэбулган	69.7	2.36		50.0	
13	Арбулаг	91.6	3.1	4.0	40.0	
14	Галт	92.6	3.13		40.0	
15	Цэцэрлэг	95.4	3.23	8.0	0.0	Хязгаарлалттай дүгнэлт авсан, залруулагдаагүй алдаатай
16	Шинэ-Идэр	98.2	3.32		0.0	Хязгаарлалттай дүгнэлт авсан
17	Улаан-Уул	104.0	3.52	1.4	0.0	алдаа, зөрчлийн дүн өндөр ихтэй
18	Алаг-Эрдэнэ	124.0	4.19		0.0	алдаа, зөрчил ихтэй, өмнөх оноос алдаа нэмэгдсэн
19	Цагааннуур	134.6	4.55		0.0	алдаа, зөрчлийн дүн өндөр ихтэй
20	Цагаан-Үүр	140.6	4.75		0.0	алдаа, зөрчлийн дүн өндөр ихтэй
21	Чандмань-Өндөр	142.7	4.83	3.4	0.0	алдаа, зөрчил ихтэй, өмнөх оноос алдаа нэмэгдсэн
22	Жаргалант	152.0	5.14	2.4	0.0	алдаа, зөрчил ихтэй, өмнөх оноос алдаа нэмэгдсэн
23	Ханх	246.9	8.35	20.0	0.0	алдаа, зөрчил ихтэй, өмнөх оноос алдаа нэмэгдсэн
24	Мөрөн	486.1	16.44		0.0	алдаа, зөрчил ихтэй, өмнөх оноос алдаа нэмэгдсэн
Дүн		2,956.9	100	42.8		